# МОНГОЛ УЛСЫН
# ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 02 өдөр Дугаар A/19 Улаанбаатар хот

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын
"2022-2025 оны үйл ажиллагааны стратеги
төлөвлөгөө" батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4, 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын 2.2, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны "Аргачлал загвар батлах тухай" 100 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын "2022-2025 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-г хавсралт ёсоор батлагсугай.

2.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын "2022-2025 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангуулж, хяналт тавихыг Тамгын газрын дарга (Ц.Адъяахишиг), нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, үр дүнг тооцон, тайлагнаж ажиллахыг хэлтэс, тасгийн дарга нарт тус тус даалгасугай.

ДАРГА Ж.ХУНАН

94

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын
даргын 2022 оны 06 дугаар сарын 02-ны
өдрийн А/19 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИСС

# МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН “2022-2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ”

**Улаанбаатар хот**
**2022 он**

## ГАРЧИГ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

**Хоёр. Мандат**

**Гурав. Алсын хараа**

**Дөрөв. Уриа**

**Тав. Эрхэм зорилго**

**Зургаа. Орчны шинжилгээ**

**Долоо. Тэргүүлэх чиглэл**

**Найм. Стратегийн зорилго, зорилт, үйл ажиллагаа**

**Долоо. Хавсралт** (ТӨЛӨВЛӨГӨӨ)

# НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

## 1.1. Стратеги төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ, шаардлага

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт "Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна", Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дүрмийн 1.3 дахь хэсэгт "Комисс нь үйл ажиллагааны хэтийн (стратеги) төлөвлөгөөтэй байна. Хэтийн төлөвлөгөөний дагуу Тамгын газар нь тухайн жилд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг Комисс, түүний гишүүний бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааг биелүүлэхэд чиглүүлнэ" гэж тус тус заасан.

Техник технологи болон нийгмийн хурдацтай хөгжлийн явцад хууль, эрх зүйн хүрээнд зохицуулах шаардлагатай асуудлууд өдөр ирэх бүр нэмэгдсээр байгаа бөгөөд энэ нь олон улсын эрх зүйн чиг хандлага, хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд нийцсэн, суурилсан байх шаардлагатай болж байна.

Иймд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон бусад хууль, тогтоомж, бодлогын баримт бичигт заасан чиг үүргээ үр нөлөөтэй, бүтээмжтэй, хариуцлагатай хэрэгжүүлэх, салбарын өмнө тулгамдаж буй асуудлыг богино болон дунд хугацаанд оновчтой шийдвэрлэх, ХЭҮК-ын Тамгын газрыг мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнээр олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор цаашид баримтлах стратегийг тодорхойлох зүй ёсны шаардлага үүсэж байна. Түүнчлэн стратеги төлөвлөгөө боловсруулах дараах хэрэгцээ, шаардлага үүсэв. Үүнд:

- ХЭҮК-ын 6 дахь стратеги төлөвлөгөө 2015-2020 онд хэрэгжиж, дуусгавар болсон;
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор чиг үүрэг, бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөн;
- "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдаж, хүний эрхийг бүрэн хангасан, хүний эрхийг дээдэлсэн нийгэмтэй болох зорилго дэвшүүлсэн;
- 2020 оноос үргэлжилж буй коронавируст цар тахал, геополитикийн нөхцөл байдлаас улбаалан нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс өөрчлөгдөж буй энэ үед хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нь өндөр ач холбогдолтой болсон байна.

Энэхүү стратеги төлөвлөгөөг "Ухаалаг" буюу зорилго тодорхой, хэмжиж болохуйц, зорилгодоо хүрч болохуйц, бодитой, цаг хугацаатай байх зарчмуудад тулгуурлан боловсруулав.

**Төлөвлөгөөний хамрах хүрээ:**

Энэхүү стратеги төлөвлөгөө нь ХЭҮК-ын чиг үүргийг Комиссын гишүүд болон түүнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааг хамруулан, нэгдмэл байдлаар хоорондоо нь цогц уялдуулж, 2022-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичиг юм.




**Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн:**.

ХЭҮК нь хүний эрх, эрх чөлөөг орон даяар, цаг ямагт хүндэтгэх, хамгаалах, дэмжих, хүний эрхийн соёлыг түгээх замаар хүн бүр эрх чөлөөтэй, эрх тэгш амьдрах, хөгжих нийгмийг цогцлоон бүтээхэд манлайлагч нь байх зорилгынхоо хүрээнд тус стратеги төлөвлөгөөнд дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, туршлагыг судлах, хүртээмжтэй өсөлт, тасралтгүй хөгжилд чиглэсэн зорилтот түвшин, хүрэх үр дүнг тооцон тусгасан.

Уг төлөвлөгөө амжилттай хэрэгжсэнээр олон талын оролцоог хангасан хүний эрхэд суурилсан бодлого, төлөвлөлтийн уялдаа холбоо хангагдаж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрэлдэн, хүний эрхийг хамгаалах, гомдол мэдээллийг хянан шалгах, хүний эрхийн боловсролыг дэмжиж, түгээх үйл ажиллагааны үр нөлөө нэмэгдэнэ.

КОМИССЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



## 1.2. Байгууллагын өмнө тулгамдаж буй асуудлууд

Стратеги төлөвлөгөөг оновчтой, бодитой боловсруулахын тулд салбарын өмнө тулгамдсан асуудлыг дараах байдлаар тодорхойлж, ач холбогдлын зэрэглэлээр нь эрэмбэлэв.

| Тулгамдсан асуудлуудын эрэмбэ | | |
|---|---|---|
| Нэн их | Их | Дунд |
| Хүний эрхийг хангах, хамгаалах төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмэр оруулах | | |
| | | Хууль тогтоомж, бодлого шийдвэр боловсруулахад хүний эрхэд нөлөөлөх байдлын үр нөлөөг тооцох аргачлалын дагуу санал өгөх, салбар хоорондын уялдаа холбоог хангах |
| Хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх чиглэлээр | | |
| Хүний эрхийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бүрдүүлэх | | Хүний эрхийн боловсрол олгох сургалт, судалгааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, салбар хоорондын уялдааг хангах |
| Хүний эрхийн Үндэсний Комиссын чадавхыг бэхжүүлэх | | |
| Бие даасан, хараат бус байдлаар ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байртай болох | Хуулиар хүлээсэн чиг үүргийг хангаж ажиллах мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, төсөв хангалттай байх | |
| Хүний эрхийн хяналт, шалгалт, гомдол шийдвэрлэх, хүний эрхийн зөвлөгөө өгөх | | |
| Хүний эрх, эрх чөлөө зөрчсөн асуудлаар хяналт шалгалт хийж, өгсөн зөвлөмж, шаардлагын хэрэгжилтийг хангуулдаг механизм бүрдүүлэх | | Гомдол шалгах, шийдвэрлэх журмыг боловсронгуй болгох замаар ХЭҮК-ын харьяалан шийдвэрлэх гомдол, мэдээлэл шийдвэрлэлтийн үр нөлөөг нэмэгдүүлэх |
| Хүний эрх хамгаалагчийг хамгаалах үндэсний механизм | | |
| | Хүний эрх хамгаалагчийг хамгаалах бие даасан, хараат бус, иргэний нийгэм, ялгаварлан гадуурхалтад өртсөн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах чиг үүрэг бүхий Хүний эрх хамгаалагчийн Хороог бүрдүүлэх | Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, хамгаалахад хяналт тавих сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хийх |
| Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм | | |
| | Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулах | Аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх |

# ХОЁР. МАНДАТ

## 2.1. Чиг үүрэг

ХЭҮК-ын чиг үүргийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан бөгөөд хамаарал бүхий нийт 21 хууль тогтоомж байна.

| № | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг |
|---|---|
| 1. | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх; |
| 2. | хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах; |
| 3. | хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах эсэх талаар санал хүргүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөл болон гэрээний хороодод мэдээлэл хүргүүлэх; |
| 4. | хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах; |
| 5. | хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх; |
| 6. | хүний эрх, эрх чөлөөг хамгаалах; |
| 7. | хүний эрхийн асуудлаар төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах; |
| 8. | шаардлагатай асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр судалгаа хийлгэх, тухайлсан асуудлаар мэргэшсэн шинжээч томилж, дүгнэлт гаргуулах; |
| 9. | жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; |
| 10. | хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; |
| 11. | төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргийн хэрэгжилтэд энэ хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих; |
| 12 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэх; |
| 13. | аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх; |
| 14. | олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах; |
| 15. | эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах; |
| 16. | хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах. |
| | **Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндсэн чиг үүрэг** |
| 17. | хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах; |
| 18. | гомдол, мэдээллийн талаар нотолгоо, баримт, мэдээлэл цуглуулах; |
| 19. | хүний эрх хамгаалагчийг хамгаалах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, энэ хуулийн 11.8-д заасан эрсдэлийн үнэлгээ хийх; |
| 20. | эрсдэлийн үнэлгээнд үндэслэн гаргасан дүгнэлтийг Комисст хүргүүлэх; |
| 21. | энэ хуулийн хэрэгжилт болон хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдалд хяналт шинжилгээ, судалгаа хийж, жил бүр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд тусгуулах; |
| 22. | хүний эрхийн хамгаалагчийн талаарх гомдол, мэдээллийн сан бүрдүүлэх. |
| | **Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг** |
| 23. | хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах, энэ талаар холбогдох байгууллагад шаардлага, зөвлөмж хүргүүлэх, холбогдох журамд санал өгөх; |
| 24. | мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах үйл ажиллагааны явцад энэ хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөнд халдсан, эсхүл халдаж болзошгүй нөхцөл бүрдүүлсэн гэж үзвэл энэ талаар ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж, шийдвэрлэх, эсхүл өөрийн санаачилгаар шалгаж, шийдвэрлэх, уг асуудлаар холбогдох байгууллагад шаардлага, зөвлөмж хүргүүлэх; |

| | |
|---|---|
| 25 | Хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагад шаардлага, зөвлөмж өгөх; |
| 26. | мэдээлэл хариуцагчийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний талаар ирүүлсэн бүртгэлийг хүлээн авч хянан, цаашид анхаарах зүйлийн талаар зөвлөмж өгөх; |
| 27. | мэдээлэл хариуцагчийн энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж өгөх; |
| 28. | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд мэдээлэл хамгаалах үйл ажиллагаа, гарсан зөрчил, мэдээллийн эзний эрхийн хэрэгжилтийн талаар тусгах. |
| | **Дэд чиг үүрэг** |
| | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль |
| 29. | 2 жил тутам жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх илтгэл УИХ-д өргөн барих; |
| 30. | Энэ хуулийн 14 дүгээр зүйлээс бусад зүйл, заалтыг зөрчсөн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах үндэслэл болно; |
| 31. | Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан жендэрийн эрх тэгш байдлын тухай заалтын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих, эдгээр хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар олгосон бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлнэ. |
| | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль |
| 32. | Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий, Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана. |
| | Хүүхдийн эрхийн тухай хууль |
| 33. | Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн тайланг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулах бөгөөд төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, шүүхийн захиргаа, прокурорын байгууллага, Хүний эрхийн үндэсний комиссын албан тушаалтан, мэргэжилтнийг заавал оролцуулна. |
| | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга |
| 34. | Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхагдсан гэж үзсэн хүн, ажилтан, ажилтны төлөөлөгч гомдлоо тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, дээд шатных нь албан тушаалтан, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага, хууль хяналтын байгууллага, хөдөлмөрийн хяналтын байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд тус тус гаргаж болно. |
| 35. | Ажилтан, ажил олгогч, гуравдагч этгээд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтад өртсөн гэж үзвэл гомдлоо тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, дээд шатны албан тушаалтан, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага, хууль хяналтын байгууллага, хөдөлмөрийн хяналтын байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд тус тус гаргаж болно. |

## 2.2. Чиг үүргийг хэрэгжүүлэхэд талуудын оролцоо

ХЭҮК нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хангах үндэсний тогтолцооны бүхий л байгууллагуудтай хамтарч ажилладаг. Үүнд:

Улсын Их Хурал

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүр Улсын Их Хуралд хүргүүлж, Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурал тогтоол гаргана.

# ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО




Засгийн газар

Засгийн газар Комиссын төсвийн төслийг улсын нэгдсэн төсвийн төсөлд тусгана. Комиссын дарга Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд Ерөнхий сайдын хүсэлтээр хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудлаар зөвлөх эрхтэйгээр оролцож болно. Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудалд санал өгсөн тохиолдолд Комиссын даргыг хуралдаанд байр сууриа илэрхийлэхээр оролцуулж болно. Комисс олон улсын хүний эрхийн гэрээнд нэгдэн орох асуудлаар байр сууриа илэрхийлэх, Монгол Улсын олон улсын хүний эрхийн гэрээний биелэлтийг хангуулах Засгийн газрын илтгэлд санал, зөвлөмж өгч болно.

Прокурор

Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар статистик мэдээллийг прокурорын байгууллагаас гаргуулах болон бусад хэлбэрээр хамтран ажиллана.

Шүүх, хууль сахиулах болон төрийн захиргаа, олон улсын болон иргэний нийгмийн, хэвлэл мэдээллийн байгууллагууд, иргэд, олон нийт

Хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, оролцоог хангах чиг үүргээ хэрэгжүүлэхэд хамтарч ажиллана.

Судалгаа шинжилгээний мэргэшсэн байгууллагууд

Хүний эрхийн шаардлагатай асуудлаар судалгаа хийлгэх, тухайлсан асуудлаар мэргэшсэн шинжээч томилж, дүгнэлт гаргуулах чиг үүргийн хүрээнд хамтарч ажиллана.

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА - VISION

Монгол Улсад хүний эрх,эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хөхиүлэн дэмжих, зөрчигдсөн эрхийг сэргээх тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулна.

## ДӨРӨВ. УРИА

Хүний эрх, эрх чөлөөг орон даяар, цаг ямагт, хүн бүрд

## ТАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО– MISSION

Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хөхиүлэн дэмжих, хүний эрхийн соёлыг түгээх замаар хүн бүр эрх чөлөөтэй, эрх тэгш амьдрах, хөгжих нийгмийг цогцлоон бүтээхэд манлайлагч нь байна.

## ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

**SWOT шинжилгээний арга зүй.** ХЭҮК-ын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд тулгамдаж буй асуудал, цаашид хүрэхээр зорьж байгаа зорилго, хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд SWOT шинжилгээний аргаар байгууллагын гадаад, дотоод орчныг үнэлэв. Гадаад орчны үнэлгээнд улс төр, эрх зүй, засгийн газар, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаа, нийгмийн соёл, уламжлалт ёс заншил болон хэрэглэгчийг хамруулсан. Дотоод орчныг байгууллагын бодлого, стратеги, мандат, менежментийн чадамжийг илэрхийлэх хүний эрхийн талаарх үндсэн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, манлайлал, хүний нөөц, санхүү, харилцаа хамтын ажиллагаа, гүйцэтгэл гэсэн чиглэлүүдээр үнэлсэн болно.

Судалгааг баримт бичиг, асуулга, ярилцлагын аргуудаар хийсэн.

Баримт бичгийн шинжилгээнд:

- Хууль, эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн шинжилгээ;
- Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн шинжилгээ;
- Мандатын шинжилгээ;
- Хүний эрхийн олон улсын гэрээ конвенцууд;
- Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлүүд;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан;
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн гэрээний хороодод хүргүүлсэн Хүний эрхийн төлөв байдлын илтгэлүүд;
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн гэрээний хороодоос ирүүлсэн 3 удаагийн зөвлөмж зэргийг хамруулсан.

Асуулгын аргаар:

- Байгууллагын дотоод орчин буюу менежментийн чадамжийн төлөв байдал;
- Гадаад орчны төлөв байдал;
- Хэрэглэгчийн хандлага;
- Гадаад орчны хүчин зүйлүүдийн талаарх санал;
- Стратеги төлөвлөгөөнд тусгах санал зэргийг тодорхойлуулсан.

Ярилцлагын аргаар:

- Байгууллагын удирдлагын хөгжлийн талаарх үзэл, хандлагыг тодорхойлох;

- Байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тодорхойлох, арга зүйн зөвлөгөө өгөх;
- Стратеги төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэх зэргээр ажилласан.

**Байгууллагын гадаад орчны төлөв байдал:**

| Хүчин зүйлс | Боломж | Эрсдэл |
|---|---|---|
| **Улс төр** | Хүний эрхийг хангах, хамгаалах үндэсний механизм бүрдсэн.<br>Хөгжлийн бодлогын баримт бичигт хүний эрхийг хангах зорилт дэвшигдсэн.<br>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, тогтоол гаргадаг.<br>Олон улсын гэрээ конвенцод нэгдэн орох асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэдэг.<br>Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлагдан хэрэгжиж байгаа.<br>Улсын Их Хуралд Хүний эрхийн дэд хороо ажилладаг | Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал хангалтгүй<br>Илтгэлийн хэрэгжилтийг хянах механизм сул<br>Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хүний эрхийн талаар үйл ажиллагаа хангалтгүй |
| **Эдийн засаг** | Эдийн засгийн хөгжлийн бодлого тодорхой болсон<br>Уул уурхайд аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх тодорхой бодлогуудыг дэвшүүлсэн | Хүнд үйлдвэрлэлийн хөдөлмөрлөх эрхийн асуудал судлагдаагүй.<br>Ажилгүйдлийн түвшин өндөр<br>Хөдөлмөр эрхэлж байгаа боловч амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур хэрэглээтэй хүн ам<br>Албан бус салбарын хөдөлмөр эрхлэлт 26 хувь |
| **Эрх зүй** | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Ахмад настны тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль тус тус баталсан.<br>Захиргааны журмуудыг цэгцэлсэн<br>Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах, Иргэдийн оролцоог хангах, ялангуяа эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шийдвэр гаргах түвшинд оролцох эрхийг хангах чиглэлээр ажиллаж байна. | Ялгаварлан гадуурхалтай тэмцэх, Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг<br>Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх ажиллагаа зогсонги |
| **Засгийн газар** | Хүний эрхийн Олон улсын гэрээ, конвенц, Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хангах механизм ажилладаг. Төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагыг хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулдаг.<br>Эдийн засгийг дэмжих 10 их наядын хөтөлбөр<br>Нийгмийн халамжаас хөдөлмөр эрхлэлтийн бодлого<br>Нийгмийн халамжийн бодлого, ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөрийг<br>Аюултай хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо 4 дахин буурсан | Шинээр батлагдсан хуулиудын хэрэгжилтийг зохион байгуулах ажил хангалтгүй<br>Төсвийг үйл ажиллагаа явуулахад эн тэргүүний шаардлагатай түвшинд баталдаггүй.<br>Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажил суларсан<br>Дундаж тэтгэвэр, дундаж цалингийн харьцаа 34.5 хувьд хүрсэн.<br>Техник мэргэжлийн боловсрол, Дээд боловсролтой залуучуудын ажилгүйдэл өндөр байна. |

| | | |
|---|---|---|
| | | Нийт ажиллах хүчний 40 хувь илүү цагаар ажилладаг<br>Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн |
| **Нийгэм, соёл** | Бичиг үсэг тайлагдал 98.3 хувь<br>Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан иргэдээс эрүүл мэндийн үйлчилгээ авахад төлдөг төлбөрийг хөнгөвчлөх, чөлөөлөх арга хэмжээ авсан.<br>Соёлын яам байгуулагдсан.<br>Нүүдлийн уламжлалт үндэсний соёлд тулгуурласан нийгмийн харилцааг өрх гэр бүлийн хүрээний үүднээс хүний эрхийн асуудалд ханддаг | Уламжлалт ёс заншил хүний эрхийн асуудалд сөргөөр нөлөөлдөг.<br>Өргөн уудам газар нутагтай болович хүн амын тал хувь нийслэлд төвлөрсөн, хөдөө орон нутагт тарүу байрладаг.<br>Нийгэмд тогтсон төрөөс бүхнийг шийдүүлэх гэсэн хандлага нь хүний эрх, эрх чөлөөг хангахад хүн бүрийн оролцоо эн тэргүүнд байх зарчмыг үнэ цэнгүй болгодог.<br>Дээд боловсрол нь хөдөлмөрийн зах зээлд шаардагдах ур чадвар эзэмшүүлж чадахгүй байгаа. Жендэрийн тэгш байдлыг хангах үзүүлэлт сул. Эрэгтэйчүүдийн илүү цагаар ажиллах нь эмэгтэйчүүдийнхээс 25 хувь өндөр, удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 36 хувь<br>Ядуурлын түвшин 28 хувь<br>Ядуурагд ойрхон 15 хувь |
| **Олон улсын хамтын ажиллагаа** | Монгол Улс хүний эрхийг хамгаалахад чиглэсэн олон улсын 30 гаруй гэрээ конвенц, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 20 конвенцод нэгдсэнээс гадна олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тухай Женевийн 4 конвенцын тал болсон.<br><br>Хүний эрхийн үндэсний байгууллагуудын дэлхийн холбооны гишүүн. | |

## Байгууллагын дотоод орчны төлөв байдал:

| Хүчин зүйл | Давуу | Сул |
|---|---|---|
| **Байгууллагын имиж бүрдүүлэлт** | Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Олон Улсын Зохицуулах Хороонд "А" статусаар 4 удаа магадлан итгэмжлэгдсэн,<br>Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1993/48/134 дугаар тогтоолоор батлагдсан Парисын зарчмуудад нийцсэн Хүний эрхийн үндэсний байгууллага болсон.<br>Нийгэмд өөрийн дүр төрхийг бүрдүүлсэн. | |
| **Удирдлага, зохион байгуулалт** | Хөгжлийн стратеги төлөвлөгөөг 5 удаа боловсруулан мөрдлөг болгосон. Энэ төлөвлөгөөнд үндэслэн жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан ажилладаг.<br>20 гаруй жилийн туршлагатай<br>Аймаг бүрд өөрийн төлөөлөлтэй. | Стратегийн удирдлагын үйл ажиллагаа, байгууллагын үнэт зүйл тодорхойгүй.<br>Багаар ажиллах соёл, байгууллагын бүтэц зохион байгуулалт, нэгжүүдийн ажлын уялдаа холбоо дутмаг.<br>Орчны өөрчлөлтөд зохицож хөгжих чадвар, байгууллагын гүйцэтгэлийн түвшин, ижил төсөөтэй байгууллага |

| | | |
|---|---|---|
| | | олон улсын түвшинтэй харьцуулахад хангалтгүй. |
| **Үндсэн үйл ажиллагаа** | Цаг үеийн асуудалд хариу үйлдэл үзүүлэх байдлаар ажилладаг.<br>Нийгэмд хүний эрхийн тухай ойлголтыг төлөвшүүлсэн.<br>Хүний эрхийг хамгаалах чиглэлээр хийсэн олон ажлууд нийгэмд танигдсан<br>Хүний эрх, эрх чөлөөний 21 удаагийн илтгэлийг хэлэлцүүлж, Улсын Их Хурлын шийдвэр гаргуулж хэвшсэн.<br>Хүний эрхийн сургалт, судалгаа, гомдол шийдвэрлэх талаар өөрийн арга зүйтэй болсон.<br>УИХ, Засгийн газар, иргэний нийгэм болон олон улсын байгууллагуудтай сайн хамтын ажиллагаатай. | Хуулиар олгогдсон үндсэн чиг үүргүүдээр үйл ажиллагааг тэнцвэртэй удирдах<br>Шинэ үнэт зүйл бий болгох, шинэ үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ санааг дэмжих, хэрэгжүүлэх үйл явц сул.<br>Хүний эрх, эрх чөлөөний илтгэлийн сэдвийг цаг үеийн болон олон улсын байгууллагын зөвлөмжийн дагуу тодорхойлдог.<br>Судалгааны нэгдсэн систем, мэдлэгээ хуваалцах нэгдсэн систем, мэдээллийн технологи хөгжөөгүй.<br>Байгууллага бий болгосон мэдлэгээ хуримтлуулах систем хангалтгүй. |
| **Хүмүүсийг удирдах** | Үндсэн үйл ажиллагааг хариуцаж буй ажилтнууд бүгд бакалавраас дээш зэрэгтэй. Үүнээс 40 гаруй хувь нь доктор, магистр зэрэгтэй, 90 гаруй хувь нь бүтээлч насныхан, 70 орчим хувь нь 3-аас дээш жил ажилласан, 20 орчим хувь нь төрийн өндөр албан тушаалтан болон эрхэлсэн түшмэл, 50 орчим хувь нь ахлах түшмэлээс бүрддэг мэргэшсэн хамт олон.<br>Комиссын дарга, гишүүд 6 жил тутамд шинэчлэгдэх нь байгууллагыг шинэ нөхцөл байдлаас харах, гишүүд дахин томилогдвол 12 жил хүртэл хугацаагаар ажиллах нь залгамж чанарыг хадгалах сайн талтай. | Хүний нөөцийн бодлого<br>Хүмүүсийн бие даан бүтээлчээр ажиллах дэмжлэг дунд зэрэг.<br>Ажиллах хүчнийг тогтвортой, үр бүтээлтэй ажиллах нөхцөлөөр хангах байдал сул.<br>Хүний нөөц дутагдалтай<br>Боловсон хүчний чадавх, сургалт хөгжлийн бодлого сул.<br>Нийгмийн халамж хамгааллын бодлого хангалтгүй.<br>Ажилтан албан хаагч нэг бүр тасралтгүй суралцагч байх соёл төлөвшөөгүй. |
| **Санхүүгийн удирдлага** | Батлагдсан төсвийг хүртээмжтэй ашиглах тал дээр үр дүнтэй ажилладаг. Байгууллагын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаатай. Жишээ нь: 2019 онд Олон улсын байгууллагуудын 155 сая төгрөгийн санхүүжилт бүхий төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн. | Өөрийн байргүй.<br>Санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх бодлого, дотоод аудит хангалтгүй.<br>Төрийн сан аудитын байгууллагуудтай үр дүнтэй хамтын ажиллагаа шаардлагатай. |
| **Мэдээллийн технологи** | | Мэдээллийн технологийн хангамж хүртээмж, шинэчлэл, өгөгдлийн нэгдсэн сан бүрдүүлэлт, хүний эрхийн талаарх статистик мэдээний боловсруулалт муу. |

**Гадаад, дотоод орчны шинжилгээнд тулгуурлан Комиссын баримтлах бодлого, стратеги:**

| Дотоод орчин / Гадаад орчин | **Давуу тал (Strengths)**<br>Олон Улс, Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн үндэсний байгууллага. Олон чиглэлээр хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулах арга зүй төлөвшсөн. | **Сул талууд (Weaknesses)**<br>Үндсэн үйл ажиллагаа олон чиглэлд тарамдсан<br>Менежментийн чадамж<br>Санхүү, Хүний нөөц, Мэдээллийн технологи |
|---|---|---|
| **Боломж (Opportunities)**<br>Улс төрийн дэмжлэгтэй<br>Эрх зүйн орчин бүрдсэн<br>Засгийн газар, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа сайн | **SO- бодлого, стратеги**<br>Байгууллагын нэр хүнд бүрдүүлсэн имиждээ тулгуурлан гадаад орчны боломжийг дээд зэргээр ашиглан, хүний эрхийг | **WO- бодлого, стратеги**<br>Гадаад орчны боломжид тулгуурлан хүний эрхийг хамгаалах үндсэн үйл ажиллагаа тодорхой зорилтод бүлэгт (тодорхой |

| | | |
|---|---|---|
| Эдийн засаг өсөх хандлагатай | хамгаалах үндсэн үйл ажиллагааг шинэ шатанд гаргах | асуудалд) чиглүүлэн тодорхой амжилтад хүргэх |
| **Эрсдэл (Threats)**<br>Сонгуулийн нөлөө өндөр<br>Эдийн засгийн үзүүлэлтүүд хүний эрхийн асуудлуудыг хөнддөг<br>Байгаль орчны доройтол<br>Нийгмийн уламжлал соёл, ёс заншил сөргөөр нөлөөлөх | **ST- бодлого, стратеги**<br>Гадаад орчны эрсдэлийг төр, иргэний нийгэм, хуулийн этгээд, олон улсын байгууллагууд болон иргэдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, байгууллагын имиж ашиглан даван туулах | **WT- бодлого, стратеги**<br>Хүний эрхийг хамгаалах бүх талын үйл ажиллагааг зохион байгуулах замаар эрсдэлээс хамгаалах, менежмент, санхүү, хүний нөөц, мэдээллийн технологийн чадавхыг эрс сайжруулах |

## ДОЛОО. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн төвтэй нийгмийн хөгжлийг бэхжүүлэх нь Комиссын тэргүүлэх чиглэл байна.

## НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 8.1. Стратегийн зорилго 1. Монгол Улсын хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэхэд хувь нэмрээ оруулах

Зорилт 1.1. Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын индекс боловсруулан батлуулах, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулахад хүний эрхэд нөлөөлөх үр дагаврыг үнэлэх аргачлалыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

- Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын индекс боловсруулах;
- Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын индексийг хэрэглээнд нэвтрүүлэх;
- Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид салбараар нь ангилан үе шаттайгаар хүний эрхэд нөлөөлөх үр дагаврыг үнэлэх аргачлалын дагуу давхардал, хийдэл, зөрчлийг тодорхойлох, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, санал хүргүүлэх;
- Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан аргачлалуудад хүний эрхэд нөлөөлөх үр нөлөө, үр дагаврын үнэлгээг сайжруулах санал боловсруулж, хүргүүлэх;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар батлагдсан "Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал"-д хүний эрхэд нөлөөлж болзошгүй үр нөлөөг тодорхойлох хэсэгт санал боловсруулж, хүргүүлэх.

Зорилт 1.2. Хүний эрхийг хангах, хамгаалах төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилтын хүрээнд:

Хүний эрхийг хангах, хамгаалахад ач холбогдолтой дараах хууль тогтоомжийг боловсруулахад санал өгөх. Үүнд:

- Эрүүгийн хууль;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль;

- Гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, сэтгэл санааны хохирол, гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцоог сайжруулах тухай;
- Хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь бүрэн сэргээх эрх зүйн механизмыг бий болгох тухай;
- Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай;
- Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай;
- Тайван жагсаал цуглаан хийх эвлэлдэн нэгдэх журмын тухай;
- Хэвлэл мэдээллийн тухай;
- Прокурорын байгууллагын тухай;
- Цагдаагийн албаны тухай;
- Шүүхийн шинжилгээний тухай;
- Шүгэл үлээгчийг хамгаалах тухай;
- Хүүхдийн эрхийн тухай;
- Хүүхэд хамгааллын тухай;
- Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай;
- Боловсролын багц хууль;
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай;
- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай;
- Ахмад настны тухай;
- Гүйцэтгэх ажлын тухай;
- Төрийн бус байгууллагын тухай.

Зорилт 1.3. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг шинэчлэн батлах, хэрэгжүүлэхэд нөлөөлөх зорилтын хүрээнд:

- Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг Засгийн газраас үнэлэх ажилд аргазүйн дэмжлэг үзүүлэх, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажилд манлайлж оролцох;
- Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг батлуулах, хэрэгжүүлэхэд манлайлж оролцох.

Зорилт 1.4. КОВИД-19 цар тахлын сургамжид үндэслэн нийгмийн гоц халдварт өвчнийг тандан судлах, гамшгийн хариу арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх бодлого, тогтолцоог сайжруулахад нөлөөлөх зорилтын хүрээнд:

- КОВИД-19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангаж байгаа байдалд байнгын ажиглалт, мониторинг хийж, дүн шинжилгээг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэлд тусгах;
- Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор баталсан "Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө"-г хүний эрхийг хангах зарчмуудыг тусган шинэчлэн батлах, нийтийн эрүүл мэндийн гамшгийн хариу арга хэмжээг тодорхойлох, удирдах байгууллагуудын тогтолцоог боловсронгуй болгоход нөлөөлөх.

**8.2. Стратегийн зорилго 2. Хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавих, бодитой, эерэг өөрчлөлт гаргах**

Зорилт 2.1. Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийн хэрэгжилтэд үр нөлөөтэй хяналт тавих, энэ чиг үүргийг хэрэгжүүлэх арга зүйг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

- Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалыг шинэчлэн сайжруулах, бусад салбарын хөгжлийн төслийг үнэлэх;
- Монгол Улс Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пактаар хүлээсэн үүргийн хүрээнд санхүүгийн нөөцийг үр ашигтай, зохистой хуваарилж буй байдалд Монгол Улсын төсөвт дүн шинжилгээ хийж, төсвийн хуваарилалт хүний эрхэд нөлөөлөх байдлыг тооцох аргачлал боловсруулах үйл ажиллагааг дэмжих;
- Боловсролын салбар дахь хүний эрхийн асуудлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн асуудлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн эрх, эрх чөлөөний байдлын талаар үндэсний хэмжээний суурь судалгаа хийх;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, холбогдох байгууллага, шинжээчидтэй хамтран Улаанбаатар хотод хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд ноцтой эрсдэл, хохирол учруулж болзошгүй барилга байгууламж, зам, гарц, гэрлэн дохио, гэрэлтүүлэг, хүнс, хүүхдийн тоглоомын газар, нуур цөөрөмд үзлэг хийж, эрсдэлтэй объектуудын жагсаалтыг гаргуулах, эрсдэлийн үнэлгээг үндэслэн аюулгүй болгох ажлыг үе шаттай зохион байгуулах;
- Хөдөлмөрлөх эрхийн салбарт судалгаа, дүн шинжилгээ хийж, тогтолцоог сайжруулах санал, зөвлөмж хүргүүлэх;
- Тайван хуран чуулах, хэвлэн нийтлэх, олон нийтийн байгууллага байгуулж, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх.

Зорилт 2.2. Хүний эрхийн Үндэсний Комиссоос өмнөх жилүүдэд судалж, тодорхойлсон хүний эрхийн асуудлыг бодитойгоор шийдвэрлүүлэх идэвхтэй үйл ажиллагаа явуулах зорилтын хүрээнд:

- Дотоодын шилжилт хөдөлгөөн, шилжин суурьшигчдад тулгамдсан хүний эрхийн асуудал, шийдвэрлэх арга замыг шинэчлэн тодорхойлж, Улсын Их Хуралд санал хүргүүлэх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангахад чиглэсэн бодлогын нөлөөллийн үйл ажиллагаа явуулах;
- Хохирогч төвтэй мөрдөн шалгах аргачлалыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт нэвтрүүлэх, хяналт тавих;
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, аж ахуй эрхлэх эрхийн хэрэгжилтийг үнэлэх, дэмжих бодлого, тогтолцоог боловсронгуй болгоход нөлөөлөх.

Зорилт 2.3. Шинээр үүссэн буюу төрийн бодлогоор зохицуулах шаардлагатай хүний эрх, эрх чөлөөний асуудлаар судалгаа хийх, тулгамдсан асуудлууд, сайжруулах арга замыг тодорхойлох зорилтын хүрээнд:

- Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо, сэтгэцийн өвчтэй хүмүүсийн эрхийн асуудлаар олон нийтийн оролцоотой хяналт шалгалт хийх;
- Ахмад настны эрхийн асуудлаар олон нийтийн оролцоотой хяналт шалгалт хийх;

- Уламжлалт ёс заншил, соёл, орчин үеийн хүний эрхийн үзэл хандлагын асуудлаар сэдэвчилсэн судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Аж үйлдвэрлэлийн хөгжил, технологийн дэвшлийг нэвтрүүлэхтэй холбоотой хүний эрхийн стандартыг судалж, дүн шинжилгээ хийх;
- Хот төлөвлөлтийн явцад хүний эрхэд нөлөөлөх байдлыг урьдчилан үнэлэх аргачлал боловсруулах;
- Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн эрхийн асуудлаар судалгаа хийж, нөхцөл байдлыг тодорхойлох;
- Хүүхэд үрчлэлт, гадаад улсад үрчлэгдсэн Монгол хүүхдийн асуудлаар судалгаа хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлох;
- Шинжлэх ухааны бүтээл туурвих үр шимийг хүртэх эрхийн асуудлаар судалгаа хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлох.

## 8.3. Стратегийн зорилго 3. Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд манлайлах

Зорилт 3.1. Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн чадавх бэхжүүлэх, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах зорилтын хүрээнд:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эрх зүйн шинэтгэлтэй уялдуулан аймаг, орон нутгийн түвшинд хүний эрхийн тогтолцооны шинжтэй асуудлыг таних, шийдвэрлэх арга замыг тодорхойлох чадавхыг бэхжүүлэх, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчигдсөн эрхээ шаардах иргэдийн мэдлэг, чадварыг сайжруулах хөтөлбөр боловсруулж, сонгосон аймгуудад хэрэгжүүлж эхлэх;
- Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг үр нөлөөтэй, хараат бусаар мөрдөн шалгах механизм бий болгох хувилбаруудыг тодорхойлж Улсын Их Хурал, Засгийн газарт санал, зөвлөмж хүргүүлэх;
- Гадаадад оршин сууж, сурч, ажиллаж байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үр дүнтэй, байнгын ажиллагаатай тогтолцоо бий болгох Засгийн газар, Гадаад хэргийн яамны санаачилгыг дэмжиж, зөвлөн туслах;
- Төрийн албан хаагч хүний эрхийн зөрчил гаргаж байсан эсэх талаар мэдээллийн сан бүрдүүлэх асуудлаар Төрийн албаны зөвлөлтэй хамтарч ажиллах;
- Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрхийн нөхцөл байдлыг судалж, ажилтнуудын эрх ашгийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын эздээс хүний эрхийн хангах, хамгаалах, дэмжих талаар гаргасан санаачилгыг дэмжиж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Хүүхэд хамгааллын тогтолцооны үр нөлөө, мэргэжлийн байдлыг хангуулахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хянах.

Зорилт 3.2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх зорилтын хүрээнд:

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, нэгжийг Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын дагуу байгуулж, төсөв, хүний нөөц, байр, бусад материаллаг нөхцөлөөр хангах;
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, нэгжийн албан хаагчдыг Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай

хуульд заасан чиг үүрэг, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколоор Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх чадавхыг бэхжүүлэх ажлыг олон улсын байгууллагын дэмжлэгтэй зохион байгуулах.

Зорилт 3.3. Хүний эрх хамгаалагчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгож, бэхжүүлэх зорилтын хүрээнд:

- Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүдийг сонгон шалгаруулж, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хуульчид, хүний эрхийн хамгаалагчдаас бүрдсэн Хороо байгуулах;
- Хүний эрх хамгаалагчийн хэлтсийг Комиссын Тамгын газарт байгуулж, хүний нөөц, бусад материаллаг нөхцөлөөр хангах;
- Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүд болон Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн ажилтнуудыг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх ажлыг олон улсын байгууллагын дэмжлэгтэй зохион байгуулах;
- Хүний эрх хамгаалагчийн үндэсний тогтолцоо, Хүний эрх хамгаалагчийн хорооны чиг үүрэг, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах;
- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт болон хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдалд хяналт шинжилгээ, судалгаа хийх;
- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан шаардлагатай хууль, тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах;
- Цагдаагийн байгууллагатай хамтран амь нас, эрүүл мэнд нь аюул, эрсдэлд орсон хүний эрх хамгаалагчийг хамгаалах шуурхай ажиллагааны горим тогтоох.

## 8.4. Стратегийн зорилго 4. Хүний эрхийн соёл, боловсролын үндэсний тогтолцоог бэхжүүлэх

Зорилт 4.1. Бүх нийтийн хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, соёлыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах зорилтын хүрээнд:

- Хүний эрхийн онол, эрх зүйн хэм хэмжээ, хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо, олон улсын механизмын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулсан тохиолдолд хүний эрхийн хязгаарлалтын зохицуулалтын агуулга, мөн чанарыг таниулахад чиглэсэн сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагаа явуулах.

Зорилт 4.2. Албан болон албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд:

Албан боловсролын бүх шатны сургалтын хөтөлбөр, агуулга, аргазүйг хүний эрхийн суурь зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн шинэчлэх үйл ажиллагааг манлайлан дэмжих

- Зорилтот бүлэгт чиглэсэн хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа, тэдний мэдлэг хандлагыг дээшлүүлэх, чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх;
- Төрийн албан хаагчид, хуульчид, сэтгүүлчдэд хүний эрхийн боловсрол олгох бодлого, үйл ажиллагааг дэмжих;

